

**“Орчин үеийн сургалт дахь технологийн хэрэглээ”
хичээлийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь**
(ӨМБИС-ийн ерөнхий эрдмийн хичээлийн шинэчлэлийн жишээн дээр)

Хуан Шиао Юн,
Өвөр Монгол багшийн их сургууль, Боловсролын сургууль

Хураангуй

БНХАУ-ын Өвөр Монголын Багшийн Их Сургуулиас сүүлийн жилүүдэд хэрэгжүүлж буй “Орчин үеийн сургалт дахь технологийн хэрэглээ” ерөнхий эрдмийн хичээлийн практик туршлага нь боловсролын салбарын мэдээллийн технологийг хөгжүүлэх, ирээдүйн багш мэргэжилтний мэдээлэл олж авах, боловсруулах чадварыг хөгжүүлэхэд нэн чухал ач холбогдолтой юм. Тус өгүүлэлд сургалтын үйл явцын суурь хүчин зүйлсэд түшиглэн “Орчин үеийн сургалт дахь технологийн хэрэглээ” ерөнхий эрдмийн хичээлийн зорилго, агуулга, төлөвлөлт, үнэлгээ зэрэгт цогц, нарийвчилсан үнэлэлт дүгнэлт өгсний үндсэн дээр тус хичээлийн практик цар хүрээг тодорхойлохыг зорьсон юм. Судалгааны хэсэгт хичээл, хөтөлбөр, сургалтын байгууллагын түвшинд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээгээр сургалтын бодит хүрсэн үр дүнд дүн шинжилгээ хийх замаар зорилтот түвшин хэр хангагдаж байгаа, ямар үр дүн хангагдаагүй зэргийг тодорхойлж, цаашид хэрхэн сайжруулах төлөвлөгөө гаргаж, эргэх холбоогоор сургалтад сайжруулалт хийх талаарх санал дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг

Орчин үеийн сургалт дахь технологийн хэрэглээ, зорилго, агуулга, төлөвлөлт, үнэлэлт

Удиртгал

“Орчин үеийн сургалт дахь технологийн хэрэглээ” хичээлийн хөтөлбөр нь ӨМБИС-д хэрэгжээд 6 жил болж байгаа бөгөөд энэ хугацаанд хэдийгээр маш үр дүнтэй байгаа боловч дээд мэргэжлийн багш бэлтгэх ерөнхий эрдмийн сургалтын хөтөлбөр төлөвлөгөө тасралтгүй шинэчлэгдэхийг дагалдан системийн зохицуулалт, зохион байгуулалт, практик сургалтын дутагдалтай талууд болон ур чадварын хөгжүүлэлт сул зэрэг асуудлууд үүдэн гарч, улмаар суралцагчдын практик чадварыг тодорхой түвшинд хөгжүүлэх шаардлага тавигдаж буй юм. Ялангуяа бодит байдалд суралцагчдын ерөнхий хэрэглээний мэдээллийн технологийг ашиглан сургалтын явцад үүсэх асуудлыг шийдвэрлэх чадвар хангалтгүй байгаа юм. Энэ төрлийн нөхцөл байдлыг даван туулахад нэн тэргүүнд яаравчлан хичээлийн бодит хэрэгжилтийг судалж үнэлсний үндсэн дээр сургалтын хэлбэр, арга барилыг хөгжүүлэх шаардлагатай байна.

Нэг. Хичээлийн тогтсон хэв шинж, сургалтын зорилгод анализ хийсэн нь

“Орчин үеийн сургалт дахь технологийн хэрэглээ” хичээл нь ӨМБИС-ийн багш мэргэжлийн суралцагчдын заавал үзэх ерөнхий эрдмийн хичээл бөгөөд оюутны мэдээллийн технологийг ашиглах суурь

чадварыг хөгжүүлдэгээрээ онолын бусад суурь хичээлүүдээс ялгаатай. Энэ хичээлийн гол зорилго нь мэдээллийн технологиор дэмжигдсэн сургалтын орчинд суралцагчдын төлөвлөх ур чадвар, мульти медиа хичээл боловсруулах ур чадвар болон мэдээллийн ерөнхий хэрэглээний суурь чадваруудыг төлөвшүүлэн хөгжүүлэхэд чиглэдэг. Энэ зорилгыг биелүүлэхийн тулд ерөнхий сурганы болон бусад хичээлийн агуулгатай уялдуулсны үндсэн дээр суралцагчдад заавал эзэмшвэл зохих компьютерийн ерөнхий мэдлэг, чадварыг эзэмшүүлснээр сургалтын явцад үүсч болох аливаа практик асуудлуудлаас урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх, даван туулах мэдлэг, чадвар, дадлыг олгодог. Мэдээж бид дан ганц тус хичээлээр дамжуулан сургалтын үйл явцыг мэдээлэлжүүлэх явцад багшийг хөгжүүлэх бүхий л асуудлыг шийдвэрлэж чадахгүй ч, бодит байдалд огт нийцэхгүй сургалтын тогтсон хэв шинж нь энэ төрлийн сургалтын үр дүнд итгэл алдахад хүргэж буйг үгүйсгэх боломжгүй юм.

“Хичээл ба сургалтын зорилгын үндсэн эх сурвалж бол суралцагчийн хэрэгцээ, орчин үеийн нийгмийн амьдралын шаардлага, шинжлэх ухааны хөгжил юм” (Жан Хуа, 2000, х.22). Нэн тэргүүнд, өнөөгийн сургуулиудын сургалтын үйл ажиллагаа нь зарчмын мэдлэг, үйл ажиллагааны чадвар, мэдээллийн бэлтгэл,

huangxiaoying1501@163.com

технологийн соёл, хүмүүнлэгийн боловсрол зэрэг олон талын төлөвлөлт, зохион байгуулалтын хөгжлийг дэмжин, тэдгээрийн цогц чанар, практик ач холбогдлыг гол болгодог.

Иймээс “Орчин үеийн сургалт дахь технологийн хэрэглээ” хичээлийн зорилгыг суралцагчийн ерөнхий хөгжилд үндэслэн тодорхойлох нь зүй. Удаад нь, эдийн засгийн мэдлэг, нийгмийн мэдээллийн нийлүүлэлтийг дагалдан нийгмээс мэргэжилтэнд тавих шаардлага улам бүр өсөн нэмэгдэж, багш бэлтгэх сургуулиуд нэн түрүүнд суралцагчдад ёс зүйн өндөр боловсрол олгосны үндэс суурь дээр нийгмийн шаардлагад нийцсэн ирээдүйн багш мэргэжилтнийг боловсруулах үүргийг хүлээж байна. Үүнээс гадна, дэлхий нийтээр их дээд сургуулиуд хичээл, сургалтын ажиллагааг дижиталжуулах, цахимжуулах, даяарчлах түүхэн хувьслын үедээ явна. Энэхүү хувьсал нь багш мэргэжлийн оюутан суралцагчдад компьютер болон сургуулийн дотоод сүлжээ ашиглах боломжийг олгоод зогсохгүй, тэдний суралцах арга барилд ихээхэн өөрчлөлтийг авчирч байна (Сан Шин Мин, 2015, х.27-29). Мэдээж “Орчин үеийн сургалт дахь технологийн хэрэглээ” хичээлийн практик дээр багш компьютерийн үйл ажиллагааны чадвар зэрэг бүхий л жижиг зүйлсийг анхаарч хянах боломжгүй. Учир нь сургалтанд ашиглагддаг үндсэн технологи нь зарим нэг нүдээр харж болох техник хэрэгслээс илүү чухал. Тиймээс багш “Орчин үеийн сургалт дахь технологийн хэрэглээ” хичээлийн зорилгыг тодорхойлохдоо ерөнхий технологийн дэвшилд анхаарлаа хандуулж, бодит хэрэгцээ шаардлага болон суурь технологийн тэнцвэрт байдлыг анхаарах нь гол юм.

Дээр өгүүлсэн шаардлагад үндэслэн “Орчин үеийн сургалт дахь технологийн хэрэглээ” хичээлийн зорилгыг дараах байдлаар тодорхойлж болох юм.

Мэдлэг: Суралцагч компьютер, компьютерийн программууд, цахим орчинд ажиллах зэрэг орчин үеийн сургалтад шаардагдах технологийн суурь боловсролыг эзэмших: Боловсролын салбарт ашиглагдаж буй техник, технологийн хөгжлийн түүхийг ойлгох, өдөр тутмын амьдрал, шинжлэх ухаан үйлдвэрлэл, сургалтын үйл ажиллагаан дахь компьютер технологийн хэрэглээний ач холбогдлыг ойлгох,

Чадвар: Оюутны мэдээлэл цуглуулах, найруулах, боловсруулах чадварыг хөгжүүлэх: Суралцагч компьютерийн мэдлэг чадвараа бусад хичээлдээ ашиглах, судалгаа хийх чадварыг хөгжүүлэх, асуудлыг шийдвэрлэх явцдаа шинийг сэдэх, хэрэгжүүлэх чадварыг дээшлүүлэх,

Сэтгэл зүй: Оюутны бие даан суралцах, судлах сонирхол, сэдэл, сэтгэлгээг өдөөж, хамтран ажиллах сэтгэлзүйг хөгжүүлэх: Оюутан мэдээллийн технологийн боловсролын соёл, онол, нийгмийн зэрэг асуудлыг ойлгож мэдэх, түүнд хариуцлагатай хандах сэтгэлзүйг төлөвшүүлэх.

Хоёр. Сургалтын агуулгыг чухалчлах нь

БНХАУ-ын зарим их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт үүнтэй төстэй хичээлүүд ордог ч, мэргэжлийн чиглэл, мэргэжил тус бүрийн онцлог, салбар шинжлэх ухааны онцлогоос хамааран хичээлийн агуулга харилцан адилгүй байдаг. Үүнээс гадна боловсролын технологи нь шинэ тутам хөгжиж буй шинжлэх ухааны салбар учир түүний онолын систем, практик үйл ажиллагааны бүс аажмаар тасралтгүй хөгжиж буй бөгөөд энэ нь их, дээд сургуулиудын энэ төрлийн хичээлүүдийн харилцан ялгаатай агуулга, хэлбэрт нөлөөлж байна. ӨМБИС бүс нутагтаа бага, дунд сургуулийн багш бэлтгэдэг төв их сургууль болохын хувьд “Орчин үеийн сургалт дахь технологийн хэрэглээ” хичээл нь мөн өөрийн гэсэн хөгжлийн онцлогтой. ӨМБИС-д зургаан жилийн турш хэрэгжүүлж буй “Орчин үеийн сургалт дахь технологийн хэрэглээ” хичээлийн хөтөлбөрийн агуулга, сургалтын зохион байгуулалт, мультимедиа сургалтын программ хангамжийн дизайн боловсруулалт, боловсролын мэдээ мэдээллийн хэрэглээ гэсэн гурван хэсгээс голлон бүрдэж байна.

- Сургалтын зохион байгуулалтын хэсэгт өмнөх үеийн хичээл сургалтын үйл ажиллагаанд үүсч байсан хүндрэлтэй талууд болон сургалтын гол агуулгыг загварчилдаг. Ойрын жилүүдэд сургалтын практикт үүссэн сургалтын агуулгыг хэт чангатгах, хичээл сургалтын нэгжийн зохион байгуулалт зэрэг агуулгын өөрчлөлтүүд нь оюутнуудын сэтгэлгээний ерөнхий чадварыг хөгжүүлэх болон суралцах агуулгын төлөвлөлт, мэргэжлийн онолын суурь хичээлийн үр дүнд эерэг бус нөлөөг үзүүлж байна. Иймээс сургалтын явцад сурах агуулгын төлөвлөлтийг үзэл баримтлал, үнэлэлт болгон оюутан суралцагчдад танилцуулж, голагуулгыг сургалтын үйл явцад тайлбарлан ярьснаар тэдний сургалтын төлөвлөлт хийх чадварыг аажмаар нэмэгдүүлж, хойшдын хичээл сургалтад нь суурь тавих.
- Мультимедиа сургалтын программ хангамжийн дизайн боловсруулах хэсгийн сургах гол агуулга нь мультимедиа сургалтын программ хангамжийн боловсруулах

юм. Энэ талын агуулга маш өргөн цар хүрээтэй ч оюутнууд бага, дунд сургуульд, их, дээд сургуулийн бага курсэд нэгэнт компьютерийн суурь мэдлэгийг эзэмшсэн байдаг тул тэдний хувьд тийм ч шинэ мэдлэг мэдээлэл бус байдаг. Иймээс сургалтад бага, дунд сургуулийн багш нарын байнга ашигладаг Flash программыг мультимедиа сургалтын программ хангамж боловсруулах хэрэгсэл болгон таницуулахын зэрэгцээ, туршилтын үйл ажиллагаатай хослуулан оюутанд зөв медиа арга хэлбэрийг сонгон хэрэглэх чадварыг эзэмшүүлж байна.

- Боловсролын мэдээ мэдээллийн хэрэглээ хэсэгт компьютерт суурилсан мэдээллийн технологийн хэрэглээ, түүний дотор компьютер ашиглан мэдээлэлд анализ хийх, боловсруулахад суралцах, ирээдүйн багш нарын мэдээллийн технологийн бэлтгэл чадварыг цогцоор нь дээшлүүлэхэд чиглэгдэнэ. Ингэхдээ шинжлэх ухааны хөгжлийн шинэ хандлагыг таньж мэдэн, алсын зайн сургалт, мэдээлэл харилцаа холбоо, насан туршийн боловсрол зэрэг боловсролын шинэ систем, шинэ үзэл баримтлалд хэрхэн хэрэгжүүлбэл зохистойг танилцуулах. Сургалтын зорилго, агуулгад үндэслэн ур чадварын болон үйл ажиллагааны чиг үүрэг гэсэн хоёрт хэсэгт авч үзэж болно. “Орчин үеийн сургалт дахь технологийн хэрэглээ” хичээлийн мэдлэг, ур чадварт тус хичээлийн үндсэн мэдлэг, мультимедиа сургалтын дизайн төлөвлөлт, Flash мультимедиа программ, боловсролын мэдээ мэдээллийн ерөнхий хэрэглээ зэргийг багтаана. Харгалзах үйл ажиллагааны чиг үүрэгт тайлбар яриа, дизайн төлөвлөлтийн үйл ажиллагаа, Flash боловсруулалтын үйл ажиллагаа болон хэрэглээ үнэлгээний үйл ажиллагааг багтаан үзнэ. Хүснэгтээс харна уу.

Хүснэгт 1. Мэдлэг, чадвар, үүрэг

Агуулга	Мэдлэг, ур чадвар	Боловсрол судлалын үйл ажиллагаа, агуулга
Суурь мэдлэг	Боловсролын технологийн үзэл баримтлал, өөрчлөлт, боловсрол сурганы чиг үүрэг, хөгжлийн чиг хандлага, хэрэглээний хэлбэр	Багшийн тодорхой ярьж тайлбарлах, үнэлж дүгнэх. Оюутан бие даан суралцах онолын мэдлэг

Flash программ	Flash танилцуулга, файл үүсгэх, илтгэх болон засварлах, боловсруулах, сайжруулах, сургалтын программ хангамжийг хэсэгчлэн боловсруулах	Оюутны үйл ажиллагаа: Script бичих, текст, зургийг хөдөлгөх ашиглах, мэргэжлийн сургалтын программ хангамж боловсруулах
Төлөвлөлт	Сургалт төлөвлөлтийн үндсэн үйл явц, зорилго, агуулга, суралцагч, медиа, стратеги сонголт ба загвар	Багшийн удирдлагаар сургалтын төлөвлөгөө хийх, оюутнууд Flash-тай уялдуулж бүрэн хэмжээний программ хангамжийн скрипт боловсруулах
Ерөнхий хэрэглээ	Заан сургалтын төлөвлөлт, Script зураг төсөл, программ хангамжийн гурвалсан нийлэмж, “Орчин үеийн сургалт дахь технологийн хэрэглээ” программын үнэлгээ	Шинэ бүтээгдэхүүнийг сургалтанд нэвтрүүлэх, программ хангамжийн үнэлгээ, үзүүлэлтийн индекс, өөрийн үнэлгээ, бүрдэл хэсэг ба бусад бүрдлийг боловсруулах

Гурав. Сургалтын стратеги төлөвлөлт, түүний сонголт

Өнөөгийн түвшинд ӨМБИС “Орчин үеийн сургалт дахь технологийн хэрэглээ” хичээлд дадлага, бие даалт хосолсон сургалтын хэлбэрийг ашиглаж байна. Гэвч тус хичээлийн цаг бага (40 цаг), агуулга их, ач холбогдол өндөр учир агуулгыг хэт шахааж, үүний улмаас практик чанарын үзүүлэлт ихээр буурсан. Үүнээс гадна, том танхимд олон оюутанд лекц хэлбэрээр хичээллэхэд тайлбар яриагаар голлож, эхнээсээ дуустал хэвлэмэл мэдээлэл эсвэл мультимедиа танилцуулга ашиглаж байгаа нь хичээлийн үндсэн чанарыг алдагдуулж байна. Ийм нөхцөлд үндсэн зорилгод нийцүүлэн тус хичээлийн стратеги төлөвлөлт, арга хэлбэрийг шинэчлэн сайжруулах шаардлагатай байна.

“Орчин үеийн сургалт дахь технологийн хэрэглээ” хичээлийн чиг үүрэгт үндэслэн сургалтын өмнөх бэлтгэл төлөвлөлт, сургалтын явцыг хэрэгжүүлэх төлөвлөлт, сургалтын дараах үнэлгээний төлөвлөлт (Шян Лян Фан нар, 1999,

х.98) гэсэн гурван үе шаттайгаар гол холбоосыг тогтоох нь зүйтэй гэж үзэж байна.

1. Стратеги боловсруулах — Сургалтын багийг төлөвлөж, зохион байгуулалтын хэлбэрийг сонгох

Сургалтын баг нь багш нар ба суралцагчдаас бүрдэнэ. Багш нарын баг нь онолын ба дадлагын багшаас бүрдэх бөгөөд тэднийг сургалтыг амжилттай явуулах зорилго нь нэгтгэх болно. Багш нар хамтын ажиллагааны хүрээнд мэдээллийн технологийн хэрэгслийг сургалтын нийтлэг эх сурвалж болгон, дундын асуудлыг шийдвэрлэж, нягт хамтран ажиллана. Мэдээж, ийм багийн ажиллагаа нь багшийн хувийн дарамтыг багасгаж, сургалтын үр дүн болон ач холбогдлыг өргөж, сургалтын үйл ажиллагааг удирдан чиглүүлэгчийн хувьд өөрсдийн практик үйл ажиллагаагаар “Орчин үеийн сургалт дахь технологийн хэрэглээ” хичээлийн үзэл баримтлал, мөн чанарыг баталгаажуулах бүрэн боломжтой. Мөн түүнчлэн багшийн баг нь суралцагчдын ахиц хөгжил, сурах үйлийг дэмжин идэвхжүүлэх үүргийг хүлээнэ. Энэ нь хичээлийн үйл явц болон сургалтын агуулгын харилцан хамаарлыг нягтруулж, тус хичээлээр дамжуулан оюутанд орчин үеийн боловсролын салбар дахь технологийн хэрэглээний тухай мэдлэг, чадварыг эзэмшүүлэх гол зорилго, чиг үүрэгт нийцүүлэн сурагчдын явцад суралцагчдад учрах дарамт тасралтгүй өсөн нэмэгдэх хүндрэлийг бууруулах арга хэмжээг авч ажиллахад ч давхар ач холбогдолтой юм.

Хамгийн чухал нь өнөөгийн мэдээллийн технологийн шинэ ололт амжилтуудыг сургалтын танхимд авчирч танилцуулж буй явдал нь оюутнуудад цаг үетэйгээ хөл нийлүүлэн урагшлах, хөгжих боломжийг бүрдүүлэх явдал болно. Сургалтын багийг бүрдүүлэхэд нэн тэргүүнд суралцагчдын бүрэлдэхүүнд үндэслэн багш нарын багийн бүрэлдэхүүнийг сонгон бүрдүүлэх нь зүйтэй.

Ерөнхий эрдмийн хичээлийг ихэвчлэн том танхимд олон оюутны дунд лекц хэлбэрээр явуулсаар ирсэн нь зарим асуудлыг дагуулдаг. “Орчин үеийн сургалт дахь технологийн хэрэглээ” хичээлийг явуулахдаа хөгжилтэй орнуудын сургалт зохион явуулдаг хэлбэрээр урсгал лекц, багийн сургалтын ажил, бие даасан туршилт хавсарсан хэлбэр (Шян Лян Фан нар, 1999, х.72-74) ээс суралцаж болох юм. Эдгээр сургалтын хэлбэрийг харилцан уялдуулан нөхвөрлөснөөр тус тусын давуу талыг нэмэгдүүлж, хичээлийн ерөнхий зорилго агуулгад нийцүүлэх боломжтой юм. Цагийн хуваарилалт: Лекц 50%, багийн ажил 25%, туршилт 25%. Олон оюутанд лекцийн

хичээл ороход багшийн яриа хичээлийн гол болдог хэвшмэл байдлыг өөрчилвөл багш оюутан хамтран судалгааны сэдэв, хэлбэрийг тогтоох боломж нээгдэнэ. Өнөөгийн нөхцөлд оюутны тоо олон, хичээлийн цаг бага зэргээс шалтгаалан багийн сургалт хичээлийн нийт цагийн дөнгөж ¼-ийг эзэлж байгаа учир багаар ажиллах, суралцах цагийг нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байгаа юм.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх — Яриа болон судалгааны ажил, ур чадварт суралцах, суралцсанаа хуваалцах

“Орчин үеийн сургалт дахь технологийн хэрэглээ” хичээлийн үндсэн онцлог нь хичээлийн агуулгыг дан ганц тайлбарлан ярих буюу лекцийн хэлбэрээр явуулахад учир дутагдалтай байдагт оршино. Иймээс багш нэн түрүүнд хичээлийн агуулгыг цомхотгон сийрүүлж, дараа нь суралцагч оюутнуудыг эх сурвалжтай танилцах, судалгаа явуулах, бүлгээр хэлэлцэх зэрэгт удирдан чиглүүлж, тэдгээрийн үр дүнг нэгтгэн зангидаж, яриа хэлэлцээний сэдвийг тогтож төлөвлөснөөр, эцэст нь мультимедиа хичээлийн хөтөлбөрийг гаргаж таницуулна. Энэ ажиллагаа нь багийн сургалт болон ангийн сургалтын уялдаа хамаарлыг нягтруулж, оюутан бүрийн сурах сонирхлыг өдөөж, хүн бүрийн жигд оролцоо, хамтын ажиллагааг дэмжиж, мэдээлэл солилцох, хуваалцахад үр дүнтэй юм.

Ур чадварын эрэл хайгуулд суралцсанаар суралцагч бүр сурлагын талбарт олгогдсон нөөц боломждоо түшиглэн Flash программын үндсэн мэдлэг, чадварыг эзэмшсэнээр холбогдох асуултад хариулах болон үндсэн туршилтын ажлыг гүйцэтгэх чадвартай болно. Энэ төрлийн сурах үйл ажиллагааны хэлбэр нь суралцагчаас компьютерийн программууд дээр ажиллах үндсэн чадвараас гадна, бие даан эрэл хайгуул хийх, судлах, төлөвлөх, боловсруулах зэрэг тал талын чадварыг шаардаж, тэднийг бие даан суралцах, туршлага эзэмших, хуримтлуулах бодит туршилтын талбарт аваачдаг. Энэ нь оюутны компьютерийг ганцаарчлан болон хамтран ажиллуулах, ашиглах чадварыг хөгжүүлэхийн тулд болно.

Суралцсанаа түгээх гэдэг нь хийж гүйцэтгэсэн бүтээлээ дэлгэж үзүүлэхийг хэлж байна. Оюутан нэн түрүүнд өөрийгөө илэрхийлэх болон өөрийнхөө бүтээлд дотоод (өөрөө өөртөө) үнэлэлт хийсний дараа багийн гишүүд харилцан үнэлж дүгнэн, харилцан суралцаж, хамгийн сүүлд бүх анги хамт олноороо цахим сүлжээ ашиглан харилцан бүтээлээ дэлгэн үзүүлэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж болно. Бүтээлийг дэлгэн үзүүлэх үйл явцад суралцагчид

мэдлэг, тенологит суралцах орчныг үнэлж, харилцан суралцаж, туршлаг солилцон, харилцан ойлголцож урамших боломж нээгдэнэ гэж үзэж байна..

3. Үнэлгээний төлөвлөлт — сургалтын тэмдэглэл, багийн бичил судалгааны тайлан, тойм дүгнэлт бичих

Сургалтын үнэлгээний тохируулгын үүрэг нь цогц сургалтын үйл явцад сургалтын стратеги төлөвлөлтийг сайжруулах, үр дүнг дээшлүүлэх холбоос хүчин зүйл болж байдаг. Өөрөөр хэлбэл, үнэлгээ нь сургалтын үр дүнг тооцож хэмжих, тайлбарлах үйл ажиллагаа бус харин суургалтын үйл ажиллагааг идэвхтэй дэмжих үйл явц юм. Ингэхээр багш суралцагчдад өөрөө өөрийгөө үнэлэх үүргийг хүлээлгэх нь угтаа тэдний суралцах идэвхийг өдөөж, дэмжиж буй хэрэг юм. Суралцагчид өөрийгөө үнэлэх, суралцагчид харилцан биенээ үнэлэх, багшийн үнэлгээ зэрэг үнэлгээний олон хэлбэр нь бүгд харилцан уялдаатай. Сургалтын явцад бий болсон үнэлгээг авч үзвэл, тухайн хичээлийн үнэлгээний арга хэлбэр нь голлон тэмдэглэл, багийн судалгааны тайлан, нэгдсэн тайлан дүгнэлт гэсэн гурван хэсгээс бүрддэг.

Тэмдэглэл хөтлөх. Оюутан тус бүр тэмдэглэл (тухайлбал, ур чадвар эзэмшсэн үйл явц, багаар ажиллах явцад олж авсан туршлага, эргэцүүлэмж гэх мэт) хөтөлж, холбогдох цахим сүлжээнд нийтлэх. Ингэснээр оюутны найруулан бичих чадварыг дадлагажуулахын зэрэгцээ мөн багш сургалтын үйл явцыг хянаж, үнэлэлт дүгнэлт өгөх боломжийг бүрдүүлэх юм.

Багийн ажлын тайлан. Тус хичээлийн хугацаанд багаар ажиллаж гүйцэтгэсэн мультимедиа сургалтын загвар боловсруулсан үйл явц, ахиц дэвшил зэргийг PPT программ ашиглан анги хамт олондоо тайлагнах.

Нэгдсэн тайлан дүгнэлт. Гол нь удирдагч багш оюутны сурах чадварын ахицыг нэгтгэн дүгнэж, оюутны бүтээлд үнэлэлт өгснөөр дараа дараагийн түвшинд ахиж дэвших суурийг тавьж өгөх.

Дөрөв. Сургалтын үр дүнгийн үнэлгээ

“Орчин үеийн сургалт дахь технологийн хэрэглээ” хичээлийн үнэлгээнд сурах үйл явцад бий болсон сурах болон нэгтгэн судлах туршлагыг голлон авч үзэх ба сурах үе шат дууссаны дараа хоёр төрлийн нэгтгэн дүгнэх арга замыг хэрэгжүүлдэг. Бодит байдалд: Бүлгийн судалгааг 20%, ердийн үр дүнг 10%, компьютерийн үйл ажиллагааны туршилтыг 40%, улирлын эцсийн шалгалтыг 30%-иар дүгнэдэг. Дээр нэгэнт өгүүлсэн үнэлгээний агуулга нь сургалтын үр

дүнгийн тойм үнэлгээний агуулгаас тодорхой харагдаж байна. Компьютерийн үйл ажиллагааны туршилтын үнэлгээнд оюутны долоо хоног бүр хийж гүйцэтгэсэн Flash бүтээлийн үнэлгээ болон сургалтын талбарт ашигласан ур чадварын үнэлгээг багтаана. Харин улирлын эцсийн шалгалт нь бичгийн буюу ялангуяа сонгох тестээс голлон бүрдсэн харьцангуй бодит туршилт байна.

Дээр дурдсанчлан сургалтын үнэлгээ нь хичээл сургалтын үйл ажиллагааны төгсгөл огтхон ч биш бөгөөд харин сургалтын үйл явцыг дэмжих арга хэрэгсэл болох юм. Гэвч өнгөрсөнд бид сургалтын үнэлгээнд шалгах чиг үүргийг хэт чухалчилж, харин үнэлэх, асуудал дэвшүүлэх, өдөөх, чиглүүлэх зэрэг чиг үүргүүдийг орхигдуулсар иржээ. Чухамдаа сургалтын үр дүнг “үнэлж дүгнэх” бус харин “шалгаж тогтоох”-ыг голлож, сургуулийн сургалтын үнэлгээний шинж чанарыг алдагдуулж ирсэн байна. Дүгнэвэл, сургалтын үнэлгээний цаана харилцан адилгүй сурах үзэл, боловсролын үзэл санаа байж, тэр шинэ арга зам, хэлбэр маягийг чиглүүлж байдаг аж. Өнөөгийн “Орчин үеийн сургалт дахь технологийн хэрэглээ” хичээлийн сургалтын үнэлгээний хувьд энэ тогтсон хэлбэрээс хараахан бүрэн ангижирч чадаагүй боловч хүний хөгжилд чиглэсэн үнэлгээний арга хэлбэрийн эхлэлийг баримталж, суралцагчийн хөгжлийг гол зорилгоо болгосон олон талт хөгжлийг дэмжихэд чиглэгдэж байна.

Ном зүй

- Жан Хуа. (2000). Хичээл ба сурганы онол. — Шанхай: Боловсролын хэвлэлийн хороо
- Сан Шин Мин. (2015). Шинжлэх ухаан, технологид суралцахуй — Мэдээллийн эриний оюутан суралцагчдын суралцах чадварыг хөгжүүлэхүй. —Бээжин: Дээд боловсролын хэвлэлийн хороо
- Ши Лян Ван нар. (1999). Сурганы онол: Хичээлийн танхим дахь сурганы зарчим, төлөвлөлт, судалгаа. Хуа Дун Багшийн Их Сургуулийн хэвлэлийн хороо

Effective practices in “application of educational technology” curriculum

*Huang Xiao Ying,
Inner Mongolia Normal University, School of Education*

Abstract

In recent years, the teaching experience of “Application of Educational Technology” in Inner Mongolia of Normal University proved that in the education information background the raise and the enhancement prospective teacher’s specialized quality will be very important. Makes concrete embarks from basic element of the teaching process, we have made a comprehensive and careful proof to the public class teaching goal , course contents, teaching strategy and teaching appraisal of the Higher pedagogical universities, so based on this it has formed the practice frame which “Application of Educational Technology” curriculum implements.

Key words

Application of Educational Technology, goal, content strategy, evaluation
